**МОНГОЛ УЛСЫН**
**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41, 32-09-16
И-мэйл: moh@moh.gov.mn, http://www.mohs.mn

2019.11.08 № 1а/5077

танай ____________-ны № ____________-т

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛЭГ, ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН ТӨВ, БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВ, НЭГДСЭН ЭМНЭЛЭГ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА, ЗАХИРАЛ НАРТ

Уриалга хүргүүлэх тухай

Эрүүл мэндийн яамнаас “Дэвшилтэд нийгэм бидний оролцоо” ТББ-тай хамтран “Инээмсэглэл бидэнд урам” зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Хөтөлбөр хэрэгжсэнээр эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнууд болон иргэдийг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөв хандлагыг төлөвшүүлэх чухал ач холбогдолтой юм.

Энэхүү ажлын хүрээнд эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтан, иргэдийн хооронд эерэг зөв хандлагыг харуулсан теле зохиомжуудыг бэлтгэн хүргэж, “Инээмсэглэл бидэнд урам” зурагт хуудас хийж, хэвлэл мэдээлэл, олон нийтийн хэрэгслээр сурталчилж соён гэгээрүүлэхээр төлөвлөж байна.

Иймд дээрх үйл ажиллагааг салбарын хэмжээнд дэмжиж, хэрэгжүүлж буй ажлыг үр дүнтэй хамтран зохион байгуулахад идэвх, зүтгэлтэй санаачлагатай ажиллахыг нийт эрүүл мэндийн салбарын ажилтан, албан хаагч та бүхнээсээ хүсч, энэхүү уриалгыг хүргүүллээ.

САЙД Д.САРАНГЭРЭЛ

089571